



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

(албан тушаал)

Тэмдэг



ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

/Б.ЗОРИГТБАЯР/

(огноо)

2025.05.09

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТАЛСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)



ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

/Д.САЙЗМАА/

(огноо)

ГАРЧИГ

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын удиртгал үг

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ /ТУЛГАМДСАН АСУУДЛУУД/

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛ

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

ДОЛОО. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТУУД

НАЙМ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ЗУРАГЛАЛ

ЕС. ХАВСРАЛТ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь анх аймгийн Засаг даргын 2014 оны Б/05 дугаар захирамжаар "Дотоод аудитын алба" нэртэйгээр нэг хүний орон тоотой анх байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2014 оны А/587 дугаар захирамжаар "Санхүүгийн хяналт, аудитын алба", Монгол улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор "Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба", Монгол улсын Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолоор "Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар" болон тус тус өөрчлөн байгуулагдсан.

Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулахад Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогийн баримт бичиг "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлтийн бодлого", "Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Аймгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө" зэрэг улс, орон нутгийн бодлогын баримт бичгүүдийг үндэслэл болголоо.

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам", Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралт "Дотоод аудитын дүрэм", Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 дугаар тушаалаар баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал, загвар"-ын хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын **2025-2028** онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулав.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд үндэслэн байгууллагын алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэх хэрэгцээ шаардлагаар "Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар"-ын стратеги төлөвлөгөөг боловсруулах зайлшгүй шаардлага үүсэж байна.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмыг баримтласан болно. Үүнд:

1. Үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх
2. Нэгдмэл цогц харилцан уялдаатай байх
3. Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх
4. Судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх
5. Нөөц бололцоонд үндэслэсэн байх
6. Ил тод, нээлттэй байх
7. Төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх

Энэхүү стратеги төлөвлөгөө нь "Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар"-ын **2025-2028** оны бодлого, үйл ажиллагаандаа баримтлах бодлогын баримт бичиг юм. Стратеги төлөвлөгөө батлагдан хэрэгжсэнээр байгууллагын өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаагаа сайжруулахад чухал үүрэгтэй.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Байгууллагын стратеги төлөвлөгөөг оновчтой бодитой боловсруулахад тулгамдаж буй анхаарах асуудлуудыг тодорхойлж ач холбогдлоор нь эрэмбэлсэн.

Тулгамдаж буй анхаарах асуудлууд

Хүснэгт: 1

№	Анхаарах асуудал, хэрэгцээ	Шалтгаан
1	Албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаа	1. Цалин хөлс, урамшуулал хүрэлцэхгүй байх 2. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн үр дүн муу
2	Хүний нөөцийн дутагдал, хомсдол	1. Тогтвор суурьшилтай ажиллах хөшүүрэг муу 2. Цалин бага 3. Мэргэшүүлэх сургалт хангалтгүй
3	Ажлын ачаалал, ажил үүргийн давхардал	1. Үндсэн чиг үүргээс бусад ажил их
4	Олон нийтийн хандлага	1. Төрийн хяналтын байгууллагын нэр хүнд, үнэлэмж муу
5	Төсөв санхүүгийн хүрэлцээ муу	1. Батлагдсан төсвийн хүрэлцээ муу 2. Хөрөнгө оруулалт хязгаарлагдмал
6	Агаар, хөрс, орчны бохирдол	1. Хот доторх хог хаягдал их 2. "Эрдэнэт-Үйлдвэр" ХХК-ийн хиймэл нуурын цагаан тоос их 3. Иргэдийн соёл, хандлага муу
7	Улс төрийн нөлөө	1. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтэд нөлөөлөх
8	Техник, тоног төхөөрөмж	1. Суурин болон зөөврийн компьютерийн хүчин чадал, үзүүлэлт, хурд муу 2. Ашиглалтын хугацаа дууссан
9	Эрх зүйн орчин	1. Хууль тогтоомж хэрэгжилт бүрэн хангагддаггүй 2. Бодлогын баримт бичгийн уялдаа холбоо сул

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандат нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагад хуулиар олгосон чиг үүрэг эрх хэмжээтэй шууд холбогдоно. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Чиг үүрэг дахин хуваарьлах аргачлал"-д "Чиг үүрэг" гэдэг нь төрийн байгууллагад эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэлийг хэлнэ гэж заасан.

Дээрх хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зүйл заалтуудыг нэгтгэн ерөнхий чиг үүрэг 1, үндсэн чиг үүрэг 3, дэд чиг үүрэг 8, хамтран хэрэгжүүлэх 7 оролцогч талуудыг тодорхойлон "Мандатын шинжилгээ"-г хийсэн болно.

Хуулийн жагсаалт

Хүснэгт:2

Нийтлэг мөрдөгддөг хууль	Чиг үүргийн хүрээнд мөрдөгддөг хууль
1. Монгол Улсын үндсэн хууль 2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 3. Захиргааны ерөнхий хууль 4. Хөдөлмөрийн тухай хууль 5. Төрийн албаны тухай хууль 6. Төсвийн тухай хууль 7. Татварын ерөнхий хууль 8. Нийгмийн даатгалын ерөнхий хууль	1. Төрийн хяналт шалгалтын тухай хууль 2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 4. Шилэн дансны тухай хууль 5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 6. Авлигын эсрэг хууль 7. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 8. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль

Чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		16
Ерөнхий чиг үүрэг-1: Олон Улсын дотоод аудитын тогтолцоог төлөвшүүлэх, хариуцлагын тогтолцоог төлөвшүүлж, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын дотоод дүрэм журмыг шинэчлэх, харилцагч байгууллагын уялдаа холбоо чадавхыг бэхжүүлэх 2. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын бие даасан хараат бус	1. Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих 2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт тавих;	1. Сангийн яам- Удирдлага арга зүйгээр хангах, тайлан мэдээ, судалгааг хүргүүлэх 2. Аймгийн Засаг дарга- Аймгийн Дотоод аудитын хорооны дарга 3. Аймгийн Дотоод аудитын хороо- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд гүйцэтгэсэн дотоод аудит, хяналт шалгалтын тайланг хэлэлцэх, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх

байдлыг дээшлүүлэх	3. Төсвийн орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт болон санхүүжилт, зарцуулалт, үр ашиг, өглөг, авлага түүний шийдвэрлэлтэд хяналт тавих 4. Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээний санхүүжилт, зарцуулал, гүйцэтгэлд хяналт тавих 5. Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж, дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, хандив, тусламжийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих. 6. Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд хяналт тавих 7. Эрсдэлд суурилсан хяналтыг гүйцэтгэж, засаглалын эрсдэлийг бууруулах 8. Дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэх замаар эрсдэлээс урьдчилан сэргийлж харилцагч байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх	4. Төрийн Албаны Зөвлөл, салбар зөвлөл- Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тайлан мэдээ, судалгааг хүргүүлэх 5. Аймгийн Засаг даргын Тамгын газар, агентлаг, газар, хэлтэс-Хамтран ажиллах, тайлан мэдээ, судалгаа хүргүүлэх 6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх 7. Иргэд, олон нийтийн байгууллага, бусад байгууллагыг холбогдох албан хаагчдыг сургалт, мэдээ, мэдээллээр хангах
Ерөнхий чиг үүрэг-2: Монгол Улсын төрөөс баримтлах хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Байгууллагын хэмжээнд төрөөс баримталж буй бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах	Холбогдох тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах. Үүнд: 1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2. Улсын Их хурлын тогтоол 3. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 4. Засгийн газрын тогтоол	1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба 2. Аймгийн Засаг дарга 3. Аймгийн Засаг даргын Тамгын газар

	5. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Зөвлөлийн тогтоол, хуралдааны тэмдэглэл 6. Аймгийн Засаг даргын захирамж	
Ерөнхий чиг үүрэг-3: Чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, ил тод төрийн албыг төлөвшүүлэх		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Өсөн дэвжих эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлэх	1. Төрийн албаны тухай хуульд заасны дагуу албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулж, мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлсэн байна.	1. Төрийн албаны зөвлөл, аймгийн салбар зөвлөл 2. Аймгийн Засаг дарга 3. Аймгийн Засаг даргын Тамгын газар 4. Бусад мэргэжлийн сургалтын байгууллага
Ерөнхий чиг үүрэг-4: Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг ханган ажиллах	1. Байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах 2. Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn цахим системийн ашиглалт, мэдээлэл байршуулалтыг сайжруулах	1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам 2. Үндэсний дата төв 3. Аймгийн Засаг дарга 4. Аймгийн Засаг даргын Тамгын газар 5. Бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд

ХАРИЛЦАГЧ СУБЪЕКТТАЙ ЧИГ ҮҮРГИЙН ХАМААРАЛ ДЭЛГЭРЭНГҮЙ

Д/Д	Харилцагч субъект	Чиг үүргийн хамаарал	Хууль, эрх зүйн хамаарал
1	Сангийн яам, Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар	Байгууллагын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тоон тайлан, мэдээ, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр хүргүүлэх, мөн СХШУБ-ийн эрх олгох, сунгах, СХШУ/А/Б, Дотоод аудитуудыг	-Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл. 69.2 "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана." Заалт

		сургалт, мэдээ мэдээллээр хангах	
2	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn цахим системд улирал бүр мэдээлэл оруулах	- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль, эрх зүйн акт.
3	Үндэсний дата төв	Төрийн байгууллагын www.gov.mn нэгдсэн цахим хуудаст мэдээлэл байршуулах	- Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл
4	Аймгийн Засаг дарга буюу Дотоод аудитын хорооны дарга	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх	- Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. "Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх", 14.2.10 "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" заалт - Тус хуулийн 69 дүгээр зүйл. "Дотоод аудит". 69.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна." заалт
5	Аймгийн Дотоод аудитын хороо	Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, түүний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайланг хэлэлцэн шийдвэрлэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх	- Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 4.12 "Төсвийн ерөнхийлөн захирагч дэргэдээ Дотоод аудитын хороотой байж болох бөгөөд хороог тухайн төсвийн ерөнхийлөн захирагч даргална." заалт - Сангийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 29 дүгээр тушаалаар батлагдсан "Дотоод аудитын хорооны дүрэм"
6	Төрийн албаны Зөвлөл болон Салбар зөвлөл	Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт, холбогдох	- Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль, эрх зүйн акт

		тайлан мэдээ, судалгааг хүргүүлэх	
7	Аймгийн Засаг даргын Тамгын газар, агентлаг, газар, хэлтэс	Удирдах дээд байгууллагын шийдвэрийн хэрэгжилт, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах.	- Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль, эрх зүйн акт. - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль; - Авлигын эсрэг хууль; - Бусад хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль эрх зүйн акт.
8	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд	Төсвийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит болон санхүүгийн хяналт шалгалт хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах, гарсан зөрчлийг арилгуулах	- Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. "Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх" - Тус хуулийн 14.2.10. "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх". - Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл. "Төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ" заалт - Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйл. "Яам, агентлаг болон Засгийн газраас байгуулдаг төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх" заалт - Тус хуулийн 7.4. "Харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна" - Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйл. "Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт" заалт; - 8.2. "Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ." заалт - Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"
9	Иргэн, олон нийтийн байгууллага, холбогдох бусад байгууллагууд	Өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх, шилжүүлэх	- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 зүйл. "Өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх" заалт - 12.3. "Бичгээр, эсхүл цахим хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтан хүлээн авч, дарааллын дагуу бүртгэнэ." заалт

			- Тус хуулийн 16 дугаар зүйл. "Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацаа" заалт - 16.1. "Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ." заалт - Байгууллагын даргын 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/13 тоот тушаалаар баталсан "Санхүүгийн хяналт, аудитын албаны өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам"
--	--	--	---

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

"2030 он гэхэд Олон улсын дотоод аудитын тогтолцоог төлөвшүүлж, эрсдэлээс ангид, стандарт хэрэгжүүлэгч байгууллага болно."

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

"Улс, орон нутгийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад стандартад нийцсэн аудитыг гүйцэтгэж, хараат бус дүгнэлт гарган засаглалын эрсдэлийг бууруулж, хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино."

ҮНЭТ ЗҮЙЛ

"Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр харилцагчийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ."

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын үйл ажиллагаанд тулгамдсан асуудал, цаашид хүрэхээр зорьж буй зорилго, хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд гадаад, дотоод орчны талаарх судалгаа, мэдээлэлд тулгуурлан SWOT, PESTEL шинжилгээний аргыг ашиглан дүн шинжилгээ хийж гүйцэтгэлээ.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахын тулд хуулийн хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дотоод орчинд нөлөөлж буй давуу тал, сул талыг тодорхойлж, байгууллагын үйл ажиллагаанд гаднаас нөлөөлж буй боломж, эрсдэлд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг авч үзлээ.

Стратегийн зорилтыг дэвшүүлэхдээ дүн шинжилгээгээр тодорхойлсон давуу тал, боломжид тулгуурлан сул талаа сайжруулах, эрсдэлийг бууруулах зарчмыг баримтлан тодорхойлсон.

5.1 Дотоод орчны шинжилгээ:

Байгууллагын дотоод орчны шинжилгээг хийхдээ албан хаагчдаас авсан судалгааны дүнг нэгтгэж гарсан санал, зөвлөмжийг тусгасан.

Дотоод орчин	
Давуу тал	Сул тал
- Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлээ тодорхойлсон. - Дотоод хяналтын үйл ажиллагаа тогтворжсон. - Байгууллагын соёл төлөвшсөн. - Албан хаагчдын 60% нь магистрын зэрэгтэй бөгөөд мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсан. - Албан хэрэг хөтлөлтөд И-Оффис системийг бүрэн ашиглаж хэвшсэн. - Ажлын байрны тохижилт, эрүүл ахуйн шаардлага хангасан. - Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, дархлаажуулалтад хамруулдаг. - Харилцагч байгууллагын албан хаагчдад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хяналт шалгалтын танилцуулга хийх өрөөг тохижуулсан. - Нийгмийн хариуцлагын хүрээнд газрын дарга, байгууллагын Эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын үр хүүхдийг дэмжин урамшуулж ажилладаг. Хүүхдийн өрөөг өөрсдийн нөөц боломжоор тохижуулсан.	- Дотоод аудит гүйцэтгэх эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй. - Албан тушаалын чиг үүргээс гадна бусад чиг үүргийн ажил их, илүү цагийн нэмэгдэл хөлс олгох боломж хязгаарлагдмал. - Гадаад харилцаа сул. - Чадварлаг боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах, урамшуулах хөшүүрэг сул - Төсөв, хөрөнгө хүрэлцээ муу. - Зарим нэг шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт дутуу.

5.2 Гадаад орчны шинжилгээ:

Pestel шинжилгээний хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд улс төр, эдийн засаг, нийгэм, технологи, байгаль орчин, хууль, эрх зүйн хүчин зүйлүүд нөлөөлдөг. Байгууллагын амжилтыг тодорхойлох хүчин зүйлийн нэг нь урт удаан оршин тогтнох чадвар юм. Үүнийг дээшлүүлэх гол арга зам нь байгууллагын гадаад орчин нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, байгууллагын үйл ажиллагааны орчны өөрчлөлттэй оновчтой уялдуулах, зөв бодлого, зарчмыг тодорхойлох явдал юм.

Гадаад орчин	
Боломж	Эрсдэл

- Хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах болон сургалт, мэдээ, мэдээллээр хангахад шаардагдах төсвийг шийдвэрлүүлэх; - Дотоод аудитыг олон улсын стандартын дагуу гүйцэтгэх, хөгжүүлэх, туршлага судлах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай холбоо тогтоож, хамтран ажиллах; - Орчин үеийн техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх; - Санхүүгийн хяналт шалгалт, Дотоод аудитыг гүйцэтгэхдээ бие даасан хараат бус байдлыг дээшлүүлж, хууль эрх зүйн орчин бүрдүүлэх. - Албан хаагчдын ажлын ачаалалыг тэнцвэржүүлэх - Байгууллагад мөрдөгдөж буй хөтөлбөрт чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, хуулиар тогтоосон хувь хэмжээг баримтлан урамшуулалыг олгох - Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах замаар албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх - Мэдээ мэдээллийг улс, орон нутгийн хувьд түргэн шуурхай солилцох, олон нийтэд хүргэх боломж нээлттэй. - Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын бие даасан, хараат бус байдлыг дээшлүүлж, хууль эрх зүйн орчин бүрдүүлэх.	- Дотоод аудитын тухай хууль батлагдаагүй, эрх зүйн орчин бүрдээгүй. - Улс, орон нутгийн эдийн засгийн чадавх сул тул төсвийг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал. - Батлагдсан төсвөөс шалтгаалан албан хаагчдын илүү цагийн нэмэгдэл хөлс, урамшуулал олгох боломж хязгаарлагдмал байдаг нь авлига, ашиг сонирхол үүсэх. - Батлагдсан төсвөөс шалтгаалан дэвшилтэт техник, технологийг ашиглах, системийн хөгжүүлэлт хийх боломж бага. - Нэн шаардлагатай төсөв, хөрөнгийг дараа жилийн төсвийн төсөөлөлд тусгаж, дээд шатны байгууллагад хүргүүлдэг ч нэмэлт төсөв батлагддаггүй. - Улс төрийн нөлөөллөөс хамаарч хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах магадлалтай. - Агаарын бохирдол, цагаан тоос ихтэй.
--	---

Улс төрийн орчин	
Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын бие даасан, хараат бус байдлыг дээшлүүлж, хууль эрх зүйн орчин бүрдүүлэх.	Улс төрийн нөлөөллөөс хамаарч салбарын тогтвортой байдал алдагдах
Эрх зүйн орчин	
Дотоод аудитын тухай хуулийг баталж, эрх зүйн орчныг сайжруулж боловсронгуй болгох	Дотоод аудитын тухай хуулийн төсөл УИХ-д өргөн баригдсан боловч хэлэлцэн батлагдах явц удааширалтай байна.
Нийгмийн орчин	
Улс, орон нутгийн төсвийн байгууллагын хувьд санхүүгийн хяналт шалгалтаас илүү дотоод	Төрийн албаны залгамж чанар, хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй учир

аудитаар хяналт гүйцэтгүүлэх, хийлгэх хэрэгцээ болон эрмэлзэл нэмэгдэж байна.	удирдлага, нягтлан бодогч солигдогод байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа доголдох, өөрчлөлт орох магадлал их байдаг.
Гадаад харилцаа холбоо тогтоох орчин	
Дотоод аудитыг хөгжүүлэх, туршлага судлах чиглэлээр олон улсын байгууллага болон дотоод аудит хөгжсөн бусад улс, орон нутгийн байгууллагатай гадаад харилцаа холбоо тогтоох. Орхон аймгийн хэмжээний гадаад харилцаанд тулгуурлан хамтран ажиллах гэрээ байгуулах, улсын салбарын дотоод аудитын хөгжлийг судлах, хамтран ажиллах нөхцөл бололцоо, эрх зүйн орчинг судлах.	Гадаад харилцаа холбоо тогтоох нөхцөл, боломж муу. Гадаадад мэргэжлийн чиглэлээр туршлага судлах сургалт, семинарт хамрагдах санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал. Албан хаагчдын гадаад хэлний мэдлэг сул, дотоод аудитын олон улсын хөгжлийг судлах хүсэл эрмэлзэл хангалттай бус.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Байгууллага өөрийн алсын хараа, эрхэм зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд дараах стратегийн зорилтыг дэвшүүлж байна.

ЗОРИЛТ:

1. Хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын холбогдох дүрэм, журамд шинэчлэлт, сайжруулалт хийх, харилцагч байгууллагуудтай уялдаа холбоог сайжруулах
2. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын бие даасан, хараат бус байдлыг дээшлүүлэх
3. Улс, орон нутгийн төсвийг хэмнэлттэй, зүй зохистой зарцуулагдаж буй эсэхэд хяналт хийж, дүгнэлт өгөх, хариуцлагын тогтолцоог сайжруулах, засаглалын эрсдэлийг бууруулах, байгууллагын үнэ цэнийн нэмэгдүүлэх
4. Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангуулах
5. Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах
6. Нэгдсэн менежментийн тогтолцоог төлөвшүүлж, үйл ажиллагаандаа байнгын сайжруулалт хийх

ДОЛОО. СТРАТЕГИ ЗОРИЛТУУД

7.1 Стратеги зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2024 он/	Зорилтот түвшин				Санхүүгийн эх үүсвэр
				2025	2026	2027	2028	
Ерөнхий чиг үүрэг-1: Олон Улсын дотоод аудитын тогтолцоог төлөвшүүлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлж, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх								
Үндсэн чиг үүрэг-1: Хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын дотоод дүрэм, журмыг шинэчлэх, сайжруулах, харилцагч байгууллагын уялдаа холбоо чадавхыг бэхжүүлэх								
Зорилт-1 Хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын холбогдох дүрэм, журамд шинэчлэлт, сайжруулалт хийх, харилцагч байгууллагуудтай уялдаа холбоог сайжруулан ажиллах	Арга хэмжээ-1 Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг мөрдөх, шаардлагатай тохиолдолд дотоод дүрэм, журамд шинэчлэлт, сайжруулалтыг хийж, батлуулах	Хэрэгжилтийн хувь	100%	100%	100%	100%	100%	Үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ-2 Төсвийн ерөнхийлөн захирагч, дээд шатны байгууллага, бусад байгууллагатай хамтран ажиллах	Хамтран ажилласан байгууллагын тоо	5	5	6	6	6	Үйл ажиллагааны зардал
Үндсэн чиг үүрэг-2: Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын бие даасан хараат бус байдлыг дээшлүүлэх								
Зорилт-2 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын бие даасан хараат бус байдлыг дээшлүүлэх	Арга хэмжээ-1 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын эрсдэлийг үнэлж, нэгтгэх, мэдээллийн санг баяжуулах	Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо	60	60	65	65	65	Үйл ажиллагааны зардал

	Арга хэмжээ-2 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг эрсдэлийн үнэлгээнд суурилан төлөвлөж, стандартын дагуу үр дүнтэй, гүйцэтгэж, засаглалын эрсдэлийг бууруулах	Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо	60	60	65	65	65	Үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ-3 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын тоон тайланг нэгтгэх, дээд шатны байгууллагад хүргүүлэх	Жилд 2 удаа	2	2	2	2	2	Үйл ажиллагааны зардал
Зорилт-3 Улс, орон нутгийн төсвийн хэмнэлттэй, зүй зохистой зарцуулагдаж буй эсэхэд дүгнэлт өгөх, хариуцлагын тогтолцоог сайжруулах, эрсдэлийг бууруулах	Арга хэмжээ-1 Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллага, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, иргэний ирүүлсэн гомдлын дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт хийх	Хяналт шалгалтад хамрагдах байгууллагын тоо	5 байгуул-лага	Жил бүр Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.				Үйл ажиллагааны зардал
Зорилт-4 Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангуулах	Арга хэмжээ-1 Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд улирал бүр дотоод аудит гүйцэтгэх	Хэрэгжилтийн хувь	98%	98%	98%	99%	99%	Үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ-2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг	Сургалтад хамрагдах	84	84	84	84	84	Үйл ажиллагааны зардал

	хангах, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, сургалт мэдээллээр дамжуулан хуулийн хэрэгжилтийг сайжруулах, мэдээлэл оруулагч нарыг арга зүйгээр хангах	байгууллагын тоо						
Ерөнхий чиг үүрэг-2: Монгол Улсын төрөөс баримтлах хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах								
Үндсэн чиг үүрэг-3: Байгууллагын хэмжээний бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах								
Зорилт-5 Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах	Арга хэмжээ-1 Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хэрэгжилтийн хувь	98%	98%	98%	100%	100%	Үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ-2 Аймгийн ИТХ болон зөвлөлийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хэрэгжилтийн хувь	100%	100%	100%	100%	100%	Үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ-3 "Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан хамаарах заалтын хэрэгжилтийг ханган ажиллах	Хэрэгжилтийн хувь	100%	100%	100%	100%	100%	Үйл ажиллагааны зардал
Зорилт-6 Нэгдсэн менежментийн тогтолцоог төлөвшүүлж, үйл ажиллагаандаа байнгын сайжруулалтыг хийх	Арга хэмжээ-4 Нэгдсэн менежментийн тогтолцооны ISO 9001:2015, ISO 37001:2016 стандартуудын хэрэгжилтэд байнгын сайжруулалтыг төлөвлөх	Аудитад хамрагдах	Баталгаажуулах аудитад хамрагдсан.	Жил бүр баталгаажуулах аудитад хамрагдах			Үйл ажиллагааны зардал	
Ерөнхий чиг үүрэг-3: Чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, ил тод төрийн албыг төлөвшүүлэх								

Үндсэн чиг үүрэг-4: Өсөн дэвжих эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлэх								
Зорилт-7 Өсөн дэвжих эрмэлзэлтэй, чадахуйн зарчимд суурилсан, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх	Арга хэмжээ-1 Албан хаагчдыг мэргэшүүлэх болон бусад сургалтад хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлэх	Сургалтын тоо	38	38	40	40	40	Үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ-2 Улсын салбарын дотоод аудитын стандарт, Санхүүгийн хяналт шалгалтын стандарт, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын чиглэлээр албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэх, дадлагажуулах	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	3	3	4	4	4	Үйл ажиллагааны зардал
Зорилт-8 Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дээшлүүлэх	Арга хэмжээ-1 Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтийн хувь	95%	95%	96%	96%	96%	Үйл ажиллагааны зардал
Ерөнхий чиг үүрэг 4: Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах								
Үндсэн чиг үүрэг-5: Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг ханган ажиллах								
Зорилт-9 Байгууллагын мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах	Арга хэмжээ-1 Байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах	Хэрэгжилтийн хувь	85%	85%	86%	87%	88%	Үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ-2 И-оффис системийн ашиглалтыг сайжруулах		ирсэн бичиг-243, явсан бичиг-249,					Үйл ажиллагааны зардал


		Систем бүртгэсэн бүртгэлийн тоо	албан хаагчдын ажлын төлөвлөгөө- 458, өргөдөл гомдол-48, үүрэг даалгавар-70,	Жил бүр байгууллагад ирсэн бичиг, явсан бичиг, байгууллагын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, өргөдөл, гомдол, түүний шийдвэрлэлт, үүрэг даалгаврын тоо, биелэлт системд байршуулж, цахим хэрэглээг нэмэгдүүлж, цаасны хэрэглээг бууруулсан байна.				
	Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn цахим системийн ашиглалтыг сайжруулах	Хэрэгжилтийн хувь	84%	90%	90%	91%	92%	Үйл ажиллагааны зардал

НАЙМ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗУРАГЛАЛ

Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн А/17 дугаар захирамжаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын бүтэц орон тоог Төрийн захиргаа-9, Төрийн үйлчилгээ-3 орон тоотойгоор баталсан. Үүнд: Газрын дарга-СХШУАБайцаагч-1, Ахлах мэргэжилтэн-Дотоод аудитор-СХШУАБайцаагч-1, Дотоод аудитор-СХШУАБайцаагч-2, Дотоод аудитор-СХШУАБайцаагч-4, ХШҮХМэргэжилтэн-1, Архив бичиг хэргийн эрхлэгч-1, Нягтлан бодогч-1, Нярав-1 нийт 12 албан хаагчтайгаар батлагдсан бүтэц орон тооны дагуу ажиллаж байна.

Бүтэц зохион байгуулалт

/Схем1/



Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдааны хувьд жил бүрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусгах замаар бодлогын баримт бичиг, бусад арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нарийвчилсан төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.



ЕС. ХАВСРАЛТ

Ашиглагдсан хууль тогтоомж:

1. Төрийн албаны тухай хууль:

- 53 дугаар зүйлийн 53.1-д заасан "Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна" заалт;
- 53.2-д заасан "Хуульд өөрөөр заагаагүй бол стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална" гэсэн заалт.

2. Төсвийн тухай хууль:

- 14 дүгээр зүйлд заасан "Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх" гэсэн заалт; 14.2.4-д заасан "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах" гэсэн заалт;
- 14.2.6-д заасан "Хөтөлбөрийн үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган, Засгийн газрын хуралдаанд танилцуулах" гэсэн заалт;
- 14.2.10-т заасан "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалт;
- 69 дүгээр зүйлд заасан "Дотоод аудит" гэсэн заалт;
- 69.1-д заасан "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэсэн заалт;
- 69.2-д заасан "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана" гэсэн заалт;
- 69.3-д заасан "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна" гэсэн заалт;
- 69.4-т заасан "Дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй байна" гэсэн заалт;
- 69.5-д заасан "Дотоод аудитын албаны дүрмийг Засгийн газар батална" гэсэн заалт.

3. Төрийн хяналт шалгалтын тухай хууль:

- 7 дугаар зүйлд заасан "Яам, агентлаг болон Засгийн газраас байгуулдаг төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх" гэсэн заалт;
- 7.4-д заасан "Харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна" гэсэн заалт.

4. Шилэн дансны тухай хууль:

- 8 дугаар зүйлд заасан "Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт" гэсэн заалт;
- 8.2-д заасан "Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ" гэсэн заалт;
- 3 дугаар зүйлд заасан "Хуулийн үйлчлэх хүрээ" гэсэн заалт;
- 3.1-д заасан Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна" гэсэн заалт.

5. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол:

- "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"
6. *Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол:*
- "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.1-д заасан "Дотоод аудитын нэгж нь тухайн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөтэй байх бөгөөд төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч батална" гэсэн заалт;
 - 2.1-д заасан "Дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино" гэсэн заалт.
7. *Монгол улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол:*
- "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам";
8. *Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дугаар тогтоол:*
- "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам";
9. *Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал:*
- "Аргачлал, загвар батлах тухай";